



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/82

Чингис хот

Тусламжийн авто машин хүлээн авахад
зориулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшиг осолтой тэмцэх, хохирлыг богино хугацаанд арилгах зорилгоор тус аймагт Еүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотын Гал, гамшгийн удирдах газраас тусламжаар олгох гал унтраах үндсэн албаны автомашин 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Солонгос улсын Инчеон боомтоос ачигдаж ирэх тул гаалийн татварын зардлыг тооцож олгосугай.

2. Шаардагдах 1.450.000 /нэг сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010242